



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 352

Улаанбаатар хот

“Албан журмын даатгагчдын холбооны дүрэм”-ийг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 12¹ дугаар зүйлийн 12^{1.7}, 12^{1.9} дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Албан журмын даатгагчдын холбооны Удирдах зөвлөлийн 2017 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан “Албан журмын даатгагчдын холбооны дүрэм”-ийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийг дор дурдсан агуулгаар өөрчилж, 6.3.2 дахь заалтыг хасаж дүрмийг зөвшөөрсүгэй.

1/ “6.1.Удирдах зөвлөлийн дарга, гишүүний бүрэн эрхийн хугацаа 5 жил байна. Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон тохиолдолд шинээр сонгогдож батлагдсан гишүүний бүрэн эрхийн хугацаа нь чөлөөлөгдсөн гишүүний бүрэн эрхийн үлдсэн хугацаатай адил байна” гэж өөрчлөх.

2. “Албан журмын даатгагчдын холбооны дүрэм”-д Хорооноос зөвшөөрсөн өөрчлөлтийг оруулж хэлбэржүүлэн ирүүлэхийг Албан журмын даатгагчдын холбооны Удирдах зөвлөл /Б.Бат/-д үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолыг батлагдсантай холбогдуулан Хорооны 2011 оны “Албан журмын даатгагчдын холбооны дүрэм”-ийг зөвшөөрөх тухай 327 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Б.Ариунаа/-д даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН